



“АБТС ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны
06 сарын 06-ны өдрийн хурлын 1 дүгээр тогтоолын хавсралт 2

“АБТС ББСБ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журам нь “АБТС ББСБ” ХХК-ийн ББСБ /цаашид ББСБ гэх/ - ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид ТУЗ гэх/ - ийн үйл ажиллагааг зохицуулах, түүний эрх үүргийг тодорхойлоход чиглэгдэнэ.
- 1.2. ТУЗ-ийн даргыг бүх Хувь Нийлүүлэгчдийн Хурлаас дийлэнх олонхын саналаар томилох бөгөөд ТУЗ-ийн даргыг 3 /буюу 1-3/ жилийн хугацаатай сонгон ажиллуулна.
- 1.3. Компани болон гишүүн хоорондын харилцааг Иргэний хуульд заасан гэрээгээр зохицуулах ба тус гэрээнд компанийн нэрийн өмнөөс хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид "ХЭХ" гэх)-аас итгэмжлэгдэн томилогдсон этгээд гарын үсэг зурна.

ХОЁР. ТУЗ-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. ТУЗ нь ББСБ-ын эрх барих дээд байгууллага байх бөгөөд ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 2.1.1. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх
 - 2.1.2. ББСБ-ын үйл ажиллагааны хэтийн үндсэн чигийг тогтоох,
 - 2.1.3. ББСБ-ын бизнес төлөвлөгөөг батлах,
 - 2.1.4. ББСБ-ын удирдлага, зохион байгуулалтыг батлах,
 - 2.1.5. ББСБ-ын гүйцэтгэх удирдлага /гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, зээлийн газрын захирал, салбарын захирал/-ыг сонгох, өөрчлөх, түний бүрэн эрхийг тогтоох,
 - 2.1.6. Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох,
 - 2.1.7. ББСБ-ын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг бүх хувь нийлүүлэгчдийн хурлаас санал авч батлах,
 - 2.1.8. ББСБ-ын аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцөлийг тогтоох,
 - 2.1.9. ББСБ-ын Хянан Шалгах Зөвлөлийн гишүүдийг сонгох, ХШЗ-ийн ажиллах журам батлах, цалин хөлсийг тогтоох.
 - 2.1.10. ББСБ-ын зарласан хэмжээнд багтаан хувьцаа гаргах, эргүүлэн худалдан авах,
 - 2.1.11. Жил бүрийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах,
 - 2.1.12. Зарласан хувьцааны болон энгийн /үүсгэн байгуулагчид давуу эрхтэй гэдэг утгаар/ хувьцааны ногдол ашгийн хэмжээ, төлөх хугацааг тогтоох,
 - 2.1.13. Жил бүрийн цэвэр ашгаас байгуулах нийгмийн хөгжлийн сан, нөөцийн сангийн хэмжээг тогтоох,
 - 2.1.14. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой дотоод заавар, журмуудыг батлах,
 - 2.1.15. Сонирхлын эрх бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох,
 - 2.1.16. ББСБ-ын салбар болон төлөөлөгчийн газар байгуулах,

- 2.1.17. ББСБ-ыг өөрчлөн байгуулах талаар бүх хувьцаа нийлүүлэгчдийн хуралд санал оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх,
- 2.2. ТУЗ-ийн гишүүн нь байгууллага, хувь хүнд хугацаа хэтэрсэн өр төлбөргүй, эрүүгийн ял шийтгэлгүй хуулийн этгээд байна.
- 2.3. ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсоноос хойшхи хугацаанд 2.2-д заасан ТУЗ-ийн заасан ТУЗ-ийн гишүүн байх шаардлага хангахгүй нь нотлогдсон тохиолдолд ТУЗ-ийн гишүүний эрхийг бүх хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн түдгэлзүүлж болно.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- 3.1. ТУЗ нь тав (5) тооны гишүүдээс бүрдэнэ.
- 3.2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь хувь хүн байна. Хувь нийлүүлэгч биш этгээдийг зөвлөлийн гишүүнээр сонгож болно.
- 3.3. Компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон хүмүүс энэхүү журмын 3.4, 3.5 дугаар зүйлээс бусад тохиолдолд хэдэн ч удаа дахин сонгогдох боломжтой.
- 3.4. ТУЗ-ийн гишүүн нь өрсөлдөгч компанийн хувь нийлүүлэгч, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, ажилтан байж болохгүй.
- 3.5. Эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн, засгийн газар, орон нутгийн удирдлагын эсрэг захиргааны зөрчил гаргасан этгээд, мөн бизнес, санхүү, татвар, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил гаргаж, захиргааны шийтгэл хүлээсэн этгээдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгохгүй.
- 3.6. ТУЗ-ийн нарийн бичгийн албан тушаалд гишүүнээр ажиллаж байгаа хүнийг томилохгүй.
- 3.7. ТУЗ-ийн дарга ТУЗ-ийг удирдана.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ТУЗ-ИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА

- 4.1. ТУЗ-ийн гишүүдийг бүх ХЭХ-аас 1 жилийн хугацаатай сонгоно.
- 4.2. Өмнөх ТУЗ-ийн бүрэн эрх дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд дуусгавар болох ба ТУЗ-ийн шинэ гишүүдийг дээрх хурал дээр сонгоно.
- 4.3. Хэрэв хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн хуульд заасан хугацаанд хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн ХЭХ-г бэлтгэх, түүнийг зарлах, зохион байгуулахаас бусад Компанийн хууль болон энэ дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.
- 4.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох эрхтэй.
- 4.5. Хэрэв гишүүн удаан хугацаагаар үүргээ биелүүлэх боломжгүй болсон, ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан бол ТУЗ-өөс орлох хүнийг дараагийн бус ХЭХ хүртэл түр томилж болно.

ТАВДУГААР ЗҮЙЛ. НЭР ДЭВШҮҮЛЭХ

- 5.1. Санал гаргах өдөр саналын эрх бүхий хувьцааны хамгийн багадаа 5% буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.
- 5.2. Гүйцэтгэх захирал санхүүгийн жил дууссанаас хойш жар (60) хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн саналыг хүлээж авна.

5.3. Хувьцаа эзэмшигч өөрийн нэрийг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

5.4. ТУЗ нь ТУЗ-ийн гишүүнд тодорхой этгээдийг нэр дэвшүүлэх эрхтэй.

5.4.1. ТУЗ-ийн ердийн гишүүнд тавигдах шаардлага

- Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж, үүрэг бий болгох чадвартай, 18 ба түүнээс дээш настай байх;
- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал, төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх;
- Тухайн цаг хугацаанд ял шийтгэл эдлээгүй, эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдээгүй байх;

5.4.2. ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлага

- Энэхүү журмын 5.4.1 дэх хэсэгт заасан этгээд
- Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх;
- Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил албан, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх;
- Компанитай бизнесийн аливаа холбоогүй байх.

5.5. ТУЗ-д нэр дэвшигчдийг дараах байдлаар дэвшүүлж болно. Үүнд:

5.5.1. _____ (хаана), хэнд: _____ [санал хүлээж авах хүний албан тушаал];

5.5.2. _____ баталгаат шуудан[компанид бичгээр гаргасан захидал, бичгийг хүлээн авах эрх бүхий ТУЗ-ийн нарийн бичиг эсвэл өөр бусад томилогдсон ажилтан].

5.6. Нэр дэвшүүлэх саналыг бичгээр үйлдэх ба дараах зүйлүүдийг багтаана. Үүнд:

5.6.1. Санал болгосон нэр дэвшигч бүрийн эцгийн нэр, өөрийн нэр;

5.6.2. Санал гаргасан хувьцаа эзэмшигчийн эцгийн нэр, өөрийн нэр;

5.6.3. Санал гаргасан хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоо, төрөл, ангилал;

5.6.4. Санал гаргасан хувьцаа эзэмшигчийн гарын үсэг;

5.6.5. _____.

5.7. Тухайн саналд хувьцаа эзэмшигч эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурна. Итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурах тохиолдолд тухайн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хавсаргана.

5.8. ТУЗ гаргасан саналыг нягталж үзэх ба тухайн саналыг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор нэр дэвшигчийг ХЭХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

5.9. Нэр дэвшигчийг жагсаалтад оруулахаас татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг холбогдох бичиг баримтын хамт тухайн шийдвэрийг гаргаснаас хойш ажлын гурав (3) өдрийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.

5.10. Дараахаас бусад тохиолдолд нэр дэвшигчдийг жагсаалтад оруулна.

5.10.1. Хувьцаа эзэмшигч энэ зүйлийн 5.2 дугаар заалтад тусгасан хугацааг дагаж мөрдөөгүй;

5.10.2. Хувьцаа эзэмшигч энэ зүйлийн 5.1 дүгээр заалтад заасан тооны саналын эрхтэй хувьцааг эзэмшдэггүй;

5.10.3. Гаргасан санал энэ зүйлийн 5.6 дугаар заалтад тусгасан шаардлагыг хангаагүй;

- 5.10.4. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд оруулахаар санал болгосон асуудал ХЭХ-ын бүрэн эрхэд хамаарахгүй.
- 5.10.5. ТУЗ-д нэр дэвшигч жагсаалтад оруулахаас өмнө нэрээ татаж авах эрхтэй.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ. ГИШҮҮНЭЭР СОНГОХ БА ЧӨЛӨӨЛӨХ

- 6.1. Хамгийн олон тооны санал авсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсонд тооцно.
- 6.2. ХЭХ-аас ТУЗ-ийн бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно. Ингэхдээ ХЭХ-аас нийт гишүүдтэй холбогдуулан дээрх шийдвэрийг гаргаж болно.
- 6.3. ТУЗ-ийн аль нэг гишүүнийг чөлөөлөх бол гишүүний зүгээс ТУЗ-д чөлөөлөх хүсэлтээ нэг (1) сараас доошгүй хугацааны өмнө бичгээр мэдэгдэнэ.
- 6.4. Хэрэв ТУЗ-ийн гишүүдийн 50-иас илүү хувь нь ажиллах боломжгүй бол ТУЗ- өөс шинэ ТУЗ байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах шийдвэр гаргах ба ийнхүү гаргахаас өөр бусад шийдвэр гаргах эрхгүй.

ДОЛДУГААР ЗҮЙЛ. ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 7.1. Гишүүдийн эрх, үүргээ дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:
- 7.1.1. Шийдвэр гаргахдаа ул суурьтай, үнэнч шударга хандаж, компани болон хувьцаа эзэмшигчдийн язгуур эрх ашгийн төлөө ажиллана. Өөрөөр хэлбэл бүх боломжит мэдээллийг анхаарч үзэх, ойролцоо нөхцөл байдалд анхааралтай, сайтар бодож боловсруулсан шийдвэр гаргах;
- 7.1.2. Зарлагдсан хурлуудад оролцох, сонгогдсон ТУЗ-ийн хороодынхоо ажилд оролцох;
- 7.1.3. Тодорхой бус, ойлгомжгүй асуудлуудын талаар тодруулга хийж, асуулт тавих;
- 7.1.4. ТУЗ-ийн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд оролцох боломжгүй шалтгаанаа ТУЗ-д урьдчилан мэдэгдэнэ;
- 7.1.5. Дараах ашиг, сонирхлын зөрчилдөөний дүрэм, журмын дагуу ажиллана. Үүнд:
- 7.1.5.1. Гишүүнээр ажиллаж буй компани болон түүний салбар компанийн үнэт цаастай холбоотой үйл ажиллагаанд оролцох зорилго гэх мэт компанийн үйл ажиллагаа, гэрээ, төсөлд хувийн арилжаа, ашиг сонирхлын улмаас (шууд болон шууд бус) оролцох бол энэ талаар ТУЗ-ийн даргад нэн даруй бичгээр мэдэгдэх ба үнэт цаастай холбоотой үйл ажиллагааныхаа талаар мэдээлнэ;
- 7.1.5.2. ТУЗ-ийн гишүүний хувьд албан тушаалын эрх мэдлийнхээ хүрээнд гаргасан шийдвэр, үйл ажиллагааны шагнал эсвэл шагналд тооцогдохоор ямар нэгэн бэлэг, үйлчилгээ эсвэл мөнгөн орлогыг хувь хүн, аж ахуйн нэгжээс авахгүй, албан ёсны үйл ажиллагааны үеэр ерөнхий зөвшөөрөгдсөн эелдэг зан чанарын хэм хэмжээний дагуу талархсанаа илэрхийлэх ба бэлэг дурсгалын зүйлс солилцох;
- 7.1.5.3. ТУЗ-ийн гишүүнээр ажиллах үедээ олж мэдсэн нууц, дотоод болон бусад албан мэдээллийг ажиллах хугацаандаа болон компаниас халагдсан, ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш гурван (3) жилийн турш дээрх мэдээллийг бусдад задруулахгүй, хувийн ашиг сонирхол болон гуравдагч талын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;
- 7.1.5.4. Компанийн нууц мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах дотоод журмаар тогтоосон дүрэм, журмын дагуу ажиллах;

- 7.1.6. Хараат бус гишүүд хараат бус байдалд нь нөлөөлөх аливаа үйл ажиллагаанаас татгалзана. Хэрэв нөхцөл байдал байдалд өөрчлөлт орсны улмаас хараат бус гишүүн хараат бус байх боломжгүй болсон бол тухайн гишүүн энэ талаар ТУЗ-д бичгээр нэг (1) сарын дотор мэдэгдэнэ.
- 7.1.7. ТУЗ-д компанийн бизнес болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар бүрэн, дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.
- 7.2. Компанид алдагдал учруулах шийдвэрийн эсрэг санал гаргасан эсвэл санал хураалтад оролцоогүй гишүүд учирсан хохиролд хариуцлага хүлээхгүй.
- 7.3. Гишүүдийн энгийн бизнес үйл ажиллагааны хариуцлагын үндэслэл, хэм хэмжээ, бусад холбогдох нөхцөл байдлын тодорхойлолтыг харгалзан үзнэ.
- 7.4. Энэхүү дотоод журмын зөрчиж шийдвэр гаргасан гишүүд хамтдаа хариуцлага хүлээх ба хохирлыг хувь тэнцүүлэн нөхөн төлнө.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 8.1. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь энэ журмын 7 дугаар хэсэгт зааснаас гадна дараах чиг үүрэгтэй байна.
 - 8.1.1. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын гаргаж буй шийдвэр ялангуяа их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай шийдвэр нь хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлын тэнцвэр, компанийн ашиг сонирхолд болон хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх;
 - 8.1.2. Хувьцаа эзэмшигчид ялангуяа, хяналтын бус хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах үүргээ гүйцэтгэх удирдлага хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих;
 - 8.1.3. Дотоод хяналт зохих шаардлагын түвшинд ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих;
 - 8.1.4. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын шийдвэр компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байна гэж үзвэл энэ талаар бичгээр дүгнэлт хүргүүлэх, дүгнэлтийн талаар үндэслэл бүхий тайлбар ирүүлээгүй, ирүүлсэн тайлбар, үндэслэл нь бодит байдалд нийцэхгүй гэж үзвэл залруулахыг шаардах;
 - 8.1.5. 2-оос доошгүй хараат бус гишүүн хамтран Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахыг шаардах, ТУЗ уг шаардлагыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд бие даан хурал зарлан хуралдуулан шийдвэр гаргана.
- 8.2. Хараат бус гишүүдийн нэг нь ТУЗ-ийн Аудитын хороог даргална. Энэ гишүүн нь нягтлан бодох бүртгэл, аудитын чиглэлээр мэргэшсэн байна.
- 8.3. Их хэмжээний хэлцэл хийх тухай ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ санал нэгтэй гаргана.
- 8.4. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай ТУЗ-ийн шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхын саналаар гаргана.
- 8.5. Хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хэрхэн хангаж байгаа, Монголын компанийн засаглалын кодекст заасан мэдээллийг хэрхэн хүргэж байгаа байдалд хяналт тавих үүргийг ТУЗ-ийн Аудитын хороо хэрэгжүүлнэ.
- 8.6. Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж чадахгүй байна гэж Аудитын хороо үзвэл хариуцсан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа ТУЗ-д оруулан хэлэлцүүлнэ.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 9.1. Нарийн бичгийн даргыг компанийн ТУЗ-ийн даргын санал болгосноор нийт гишүүдийн олонхын саналаар томилно. Нарийн бичгийн даргад нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:
 - 9.1.1. Дээд боловсрол;
 - 9.1.2. Нарийн бичгийн даргын үүрэг хариуцлагыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын туршлага болон мэргэжлийн ур чадвартай байх;
 - 9.1.3. Компанийн тухай хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй;
 - 9.1.4. Компанийн тухай хуулийн 75.8 -д заасан шаардлагыг хангасан;
 - 9.1.5. Компанитай нэгдмэл сонирхолгүй, компанийн томоохон хувьцаа эзэмшигчдээс хараат бус этгээд байх;
- 9.2. ТУЗ-ийн гишүүд нарийн бичгийн даргад нэр дэвшигчтэй холбоотой дараах мэдээллийг хүлээн авна:
 - 9.2.1. Боловсрол, өнгөрсөн 3 жилд хашиж байсан ажлын туршлага;
 - 9.2.2. Компанид хувьцаа эзэмшдэг эсэх (хэрвээ эзэмшдэг бол хувьцааны тоо хэмжээ);
- 9.3. Компанийн нарийн бичгийн дарга нь тухайн компанийн засаглалын асуудлыг хариуцах үндсэн ажилтан байна. Нарийн бичгийн дарга нь компанийн удирдлагаас хараат бус байх бөгөөд дараах үндсэн үүргийг хүлээнэ:
 - 9.3.1. Компанийн засаглалын талаар бодлого боловсруулахад оролцох;
 - 9.3.2. Компанийн засаглалын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;
 - 9.3.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид ХЭХ гэх), Төлөөлөн удирдах зөвлөлийн (цаашид ТУЗ гэх) хурлуудыг зарлан хуралдуулах, зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авах;
 - 9.3.4. Хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад хэлтэс, газрууд үр дүнтэй мэдээлэл солилцоход хувь нэмрээ оруулах;
 - 9.3.5. Компанийн мэдээлэл, харилцаа холбоо, олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаанд хяналт тавих;
 - 9.3.6. Хувьцаа эзэмшигчээс ирсэн гомдол, хүсэлтийг хүлээн авч, тухайн асуудлыг шийдвэрлэхэд компанид туслах, компани доторх маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх.
- 9.4. Нарийн бичгийн дарга нь энэ журмаар хүлээсэн эрх, үүргээ компанитай байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу гүйцэтгэнэ.

АРАВДУГААР ЗҮЙЛ. ТУЗ-ИЙН ДАРГА

- 10.1. ТУЗ-ийн даргад тавигдах шаардлага
 - Дээд боловсролтой;
 - Даргын үүрэг хариуцлагыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын туршлага болон мэргэжлийн ур чадвартай байх;
 - Компанийн удирдах албан тушаалыг 3-аас доошгүй жил ажиллаж байсан туршлагатай.

- 10.2. Компанийн ТУЗ-ийн гишүүд өөрсдийн дундаас олонхын санал авсан гишүүнийг ТУЗ-ийн даргаар сонгоно.
- 10.3. Компанийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүнээр ажиллаж байгаа нэр дэвшигчийг ТУЗ-ийн даргаар сонгохгүй.
- 10.4. ТУЗ-ийн зүгээс нийт сонгогдсон гишүүдийн олонхын санал авсан дүнгээр ТУЗ-ийн даргыг чөлөөлөх, дахин сонгох эрхтэй.
- 10.5. ТУЗ-ийн дарга дараах үйл ажиллагааг хариуцна:
 - 10.5.1. ТУЗ-ийн ажлыг зохион байгуулах, нийт гишүүдийг санал бодлоо чөлөөтэй солилцох нөхцөлөөр хангах, хэлэлцэх асуудлуудаар нээлттэй хэлэлцүүлэг явуулах;
 - 10.5.2. ТУЗ-ийн уулзалтын хуваарь гаргаж, зохион байгуулах, хурлаар хэлэлцэх асуудлуудыг бэлтгэх, гишүүдийн зөвшөөрлийн бичигт үндэслэн санал хураалт явуулах;
 - 10.5.3. Хурлын тэмдэглэл хөтлүүлэх [бичлэг], тэмдэглэлд гарын үсэг зурах;
 - 10.5.4. Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчтэй холбогдуулан тухайн нэр дэвшигч/нэр дэвшигчид эрүүгийн гэмт хэрэг улмаас шийтгүүлсэн эсвэл захиргааны шийтгэл оногдуулсан эсэх талаар мэдээлэл авах хүсэлт гаргах;
 - 10.5.5. Компанийг төлөөлөн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй байгуулах гэрээнд гарын үсэг зурах;
 - 10.5.6. Хангалттай материалд үндэслэн зохистой хэлэлцүүлэг, санал хураалт явуулснаар ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлуудаар үр дүнтэй шийдвэр гаргах;
 - 10.5.7. Хурлаас 1-3 хоногийн өмнө гишүүдийг хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох мэдээллээр хангах;
 - 10.5.8. ТУЗ-ийн хороонуудыг байгуулах ажлыг зохион байгуулах, тус хороонуудад гишүүдийг нэр дэвшүүлэх, компанийн ажилтан, гишүүд, хороодын хоорондын харилцааг зохицуулах;
 - 10.5.9. Гүйцэтгэх захирал болон бусад удирдах ажилтнуудтай байнгын харилцаа холбоотой ажиллах;
 - 10.5.10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулах талаар хувьцаа эзэмшигчийн бичгээр гаргасан санал хүлээн авах;
 - 10.5.11. Компанийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүнд нэр дэвшүүлэх;
 - 10.5.12. ХЭХ-ыг өөр албан тушаалтан зарлаж, ХЭХ-ыг даргалах өөр этгээдийг томилсноос бусад тохиолдолд ХЭХ-ыг даргалах;
- 10.6. ТУЗ-ийн даргыг байхгүй үед хуралд оролцож буй нийт гишүүдийн олонхын санал авсан шийдвэрийн дагуу томилогдсон эсвэл ТУЗ-ийн даргын томилсон гишүүн түүнийг орлоно.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ТУЗ-ИЙН ХУРАЛ

- 11.1. ТУЗ-ийн хурлаас ТУЗ-ийн бүх шийдвэр гаргах бөгөөд ТУЗ-ийн хурал нь сард 1-ээс доошгүй удаа хуралдана. Хурал нь ээлжит бус байж болно.
- 11.2. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн хурлыг зохион байгуулж хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

- 11.3. Гүйцэтгэх захирал нь хурлын товыг ТУЗ-ийн гишүүдэд 1-3 хоногийн өмнө мэдэгдэж, хэлэлцэх асуудлын хөтөлбөрийг хүргүүлнэ.
- 11.4. ТУЗ-ийн хуралд гишүүдийн 70-аас дээш хувь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.
- 11.5. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, буюу ТУЗ-ийн хурлаас шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.
- 11.6. ТУЗ-ийн нэг гишүүн нэг саналын эрхтэй байна.
- 11.7. ТУЗ-ийн гишүүн хуралд оролцох боломжгүй бол өөрийн саналыг бичгээр гаргаж болно.
- 11.8. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. */ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд дахин санал хураалт явуулах буюу бүх хувьцаа нийлүүлэгчдээс санал авна./*
- 11.9. ТУЗ-ийн хурлын протоколд дараах зүйлсийг тусгана. Үүнд:
 - 11.9.1. Хурал хийсэн газар, цаг,
 - 11.9.2. Хуралд оролцсон гишүүд,
 - 11.9.3. Хурлаар хэлэлцсэн асуудал,
 - 11.9.4. Санал хураалтаар шийдвэрлэгдсэн асуудал,
 - 11.9.5. Гаргасан шийдвэр.
- 11.10. ТУЗ-ийн хурлын протоколын төсөлд /ноорог/ гишүүд, бэлэн болсон протоколд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурах бөгөөд, протоколын 1% нь гүйцэтгэх удирдлагад, 1% нь ТУЗ-ийн даргад хадгалагдах бөгөөд тухайн протоколын үнэн зөвийг ТУЗ-ийн дарга хариуцна.
- 11.11. ТУЗ-ийн протоколыг техник алдааны улсаас буруу тэмдэглэсэн нь хурлын шийдвэрээр хүчингүй болгох үндэслэл болохгүй.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ТУЗ-ИЙН ХОРООД

- 12.1. ТУЗ урьдчилсан хэлэлцүүлэг хийх, зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд хамгийн чухал асуудлуудыг хэлэлцэх түр эсвэл байнгын хороод байгуулна.
- 12.2. ТУЗ нь дараах хороодыг байгуулна. Үүнд:
 - 12.2.1. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо;
 - 12.2.2. Эрсдэлийн удирдлагын хороо;
 - 12.2.3. Дотоод аудитын хороо;
- 12.3. ТУЗ үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх зорилгоор шаардлатай тохиолдолд шинээр хороо байгуулж болно.
- 12.4. ТУЗ-ийн нэг гишүүн гурав (3) ба түүнээс дээш хорооны гишүүнээр ажиллахгүй.
- 12.5. Хорооны хурлыг хорооны дарга, хорооны гишүүн, мөн компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу хуралдуулна.
- 12.6. Асуудал хэлэлцэх хорооны хэлэлцүүлгийн дүнг хуралд оролцсон бүх гишүүдийн гарын үсэг зурж бичгээр гаргасан шийдвэрт тусгаж, ТУЗ-ийн даргад танилцуулна.
- 12.7. Хорооны гаргасан саналуудыг зөвлөмж гэж авч үзнэ.
- 12.8. Бусад асуудлуудыг хороодын тусгай дотоод журмын дагуу зохицуулна.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. БУСАД

- 13.1. Энэхүү Журмын нэг эсвэл хэд хэдэн заалтууд нь хүчингүй болох тохиолдолд энэ Журмын бусад зүйл, заалтууд нь хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.
- 13.2. ТУЗ нь хүчингүй болсон зүйл, заалтыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн найруулж, Журамд өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ.
- 13.3. Энэхүү Журамд иш татсан хууль тогтоомж, Компанийн журмын аливаа зохицуулалтад өөрчлөлт орсноор холбогдох зүйл, хэсэг, заалтууд өөрчлөгдсөн нь Журмын тухайн зохицуулалт хүчингүй болох үндэслэл болохгүй.
- 13.4. Энэхүү журмаар зохицуулаагүй аливаа харилцааг Монгол Улсын Компанийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомж болон Компанийн дүрэмд заасны дагуу зохицуулна.
- 13.5. Энэхүү журам нь ТУЗ-ийн хурлаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.